

ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВИЙН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 7 сарын 04 өдөр

Дугаар А/25

Улаанбаатар хот

Зарим үйлчилгээнд тариф тогтоох тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглах үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох” Засгийн газрын 196 дугаар тогтоол, “Төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагаас үйлчилгээ үзүүлэх журам”-ын 12 дугаар зүйлийн 12.1,12.3, төвийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.6.15, дах заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


Нэг. Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас ирүүлсэн 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 03/976 тоот албан бичгийн дагуу 2022 оын 6 дугаар сарын 10 -ны өдрөөс эхлэн “ХУР-Төрийн мэдээлэл солилцооны систем”, “Танилт, нэвтрэлтийн систем”-д шинээр холбогдох үйлчилгээний гэрээ байгуулах Төрийн байгууллагаас бусад хүн, хуулийн этгээдийн ХУР системээр дамжуулан үзүүлэх веб сервисийн нэгж үнийг 71 төгрөгөөг тооцохыг тогтоосугай.

Хоёр. “ХУР” болон “Танилт, нэвтрэлтийн системд”-д өмнө холбогдсон төрийн байгууллагаас бусад хуулийн этгээдтэй байгуулсан гэрээний веб сервисийн төлбөрийг 2021 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн захирлын А/25 тоот тушаалын хавсралт 1-т заасан аргачлалын дагуу тогтоосон төлбөрийг Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай гэрээ шинэчлэн байгуулах хүртэл хугацаанд хэвээр мөрдсүгэй.

Гурав. Үйлчилгээний холбогдох төлбөрийг тогтоосон хугацаанд Улсын төсөвт төвлөрүүлэхийг Нягтлан бодогч /Д.Сүглэгмаа/-д үүрэг болгосугай.

Дөрөв. Энэ тушаал гарсантай холбогдуулан холбогдох үйл ажиллагааг удирдан зохион байгуулахыг Захиргаа, төлөвлөлтийн хэлтэс /Б.Дагвасүмбэрэл/-д даалгасугай.

ЗАХИРАЛ

  
9020011093-5323304

М.БАТТУЛГА